



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2024/64/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Цэгц богд төв аудит ХХК-ийн Ахлах аудитор: Р.Цанжидмаа Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ЦЭЭЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА А.СЭВЖИДМАА
ТАНАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

Цахим хаяг: www.audit.mn

2024. 01. 26 № 03

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус Эрүүл мэндийн төв тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 2183 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тумламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох зардалд 567,419.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардалд 26,850.0 мянган төгрөгийн санхүүжилт тус тус авсан байна. Эрүүл мэндийн газраас 46,321.8 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, аж ахуй, хангамжийн материал үнэ төлбөргүй орлого авчээ.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 4 хөтөлбөр, 57 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 56 арга хэмжээг бүрэн, 1 арга хэмжээг 70.0 хувь буюу нийт дүнгээр 98.0 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд сумын Засаг даргаас 90.2 хувиар, Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээгээр 83.26 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

070200040

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ сая төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	327,718.4	273,366.8
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	940,819.5	957,701.3
	Нийт хөрөнгийн дүн	1,268,537.9	1,231,068.2
	Нийт өр төлбөрийн дүн	1,268,537.9	1,231,068.2
	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,268,537.9	1,231,068.2
	Өр төлбөр, цэвэр өмчийн дүн	1,268,537.9	1,268,537.9
Орлого үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,790,398.1	756,169.9
	Үйл ажиллагааны зардлын дүн	739,509.7	792,897.9
	Үйл ажиллагааны үр дүн	1,050,888.4	(37,469.7)
Цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийсэн үлдэгдэл	217,649.5	1,268,537.9
	Тайлант оны үр дүн	1,050,888.4	(37,469.7)
	Эцсийн үлдэгдэл	1,268,537.9	1,231,068.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	848,337.9	597,000.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	601,696.1	636,524.4
	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	246,641.8	(39,523.7)
	Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(30,7113.1)	(4,719.0)
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	215,928.7	171,685.9
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	215,928.7
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	215,928.7	171,685.9
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага цэвэр зээлийн дүн		614,393.4
	Урсгал зардал		614,393.4
	Хөрөнгийн зардал		-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		786,079.4
	Эрүүл мэндийн даатгалын сангаас		786,079.4
	Орон нутгийн төсвөөс		26,217.9
	Урьд оны үлдэгдлээс		
	Туслах үйл ажиллагааны орлогоос		2,731.00

ГУРАВ Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3.7 сая төгрөгийн 4 зөрчил¹ илэрснээс, 0.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 3.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар 3 албан шаардлагыг өгсөн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

1. Сумын Засаг даргын захирамжаар тус байгууллагын даргад 0.3 сая төгрөгийн урамшуулал илүү олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана", 3 дугаар зүйлийн 3.12-т "Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэр гаргана", гэж заасантай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон урамшуулал 0.3сая төгрөгийг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

1. Тендерт шалгараагүй 2 аж ахуйн нэгж байгууллагаас 3.4 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерт шалгарсан аж ахуйн нэгжээс худалдан авалт хийж байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Нягтлан бодох бүртгэлд бүртгэлтэй 46 нэр төрлийн 13293 эм бэлдмэлийг түүвэрчлэн эмийн санчийн үлдэгдэлтэй тулгахад 27 төрлийн 4234 ширхэг эм бэлдмэл дутуу, 5 төрлийн 389 ширхэг эм бэлдмэл илүү байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх"; 13 дугаар зүйлийн 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна"-тай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эмийн тооцоог сар бүр бодож, үлдэгдлийг баталгаажуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Эм боох материалын үлдэгдэлд хугацаа дууссан 5 нэр төрлийн 5.5 төгрөгийн эм байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-т "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх"-тэй нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Дотоодын хяналтыг сайжруулж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цээл сумын Эрүүл мэндийн төв	4	3.7	1	0.3	3	3.4	-	-	-	-	-	-
Дүн	4	3.7	1	0.3	2	3.4	-	-	-	-	-	-

Зургаа.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			